



МОНГОЛ УЛСЫН
ХУНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 05 дугаар сарын 13

№ 03/14

Улаанбаатар хот

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙД ТАНАА

Комисст Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуй бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн "... хуулийн шаардлагыг хангасан байхад ахлах мэргэжилтнээр дэвшүүлэхгүй, ...яамны удирдлагууд дуудаж ажлаас чөлөөлөгдөх өргөдлөө өг эсвэл өөр байгууллагад шилжиж ажиллах санал тавьж ажлын байрны дарамт болон ялгаварлан гадуурхалтад өртөж байна" гэх гомдол ирүүлжээ.

Комисс гомдлын мөрөөр хуульд заасны дагуу шалгах ажиллагаа явуулж, холбогдох баримтад дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна.

Гомдол гаргагч
Төрийн нарийн бичгийн дарга
өгөхгүй бол нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шилжин ажиллах" талаар удаа дараа санал тавьсны дагуу энэхүү дарамтыг тэвчихгүй байсан тул өөрийн хөдөлмөрлөх эрхээ хамгаалах гарцаагүй байдал үүсч шилжүүлэхийг нь зөвшөөрч, төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн байгууллага хооронд сэлгэн ажиллах гэрээний төслийг өөрөө боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга

Комисст өгсөн тайлбартаа "... тус яамны нь ажлаасаа чөлөөлөгдөх өргөдлөө өгөхгүй бол нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шилжин ажиллах" талаар удаа дараа санал тавьсны дагуу энэхүү дарамтыг тэвчихгүй байсан тул өөрийн хөдөлмөрлөх эрхээ хамгаалах гарцаагүй байдал үүсч шилжүүлэхийг нь зөвшөөрч, төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн байгууллага хооронд сэлгэн ажиллах гэрээний төслийг өөрөө боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга..." гэжээ.

Гомдолд дурдсан асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга мэргэжилтнийг ажлаа өг гэж дарамтлаад байгаа зүйл байхгүй. ...2020 онд хариуцсан ажилдаа алдаа дутагдал гаргаж, шалгалтаар тогтоосон боловч тухайн үед хариуцлага тооцоогүй. ...олон жил ажилласнаар нь биш ажлын ур чадвар, гүйцэтгэл сайтай нь дэвшиж ажиллахыг дэмжиж байгаа...", мөн тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга "...яамны удирдлагын зүгээс мэргэжилтэн гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг хасах, дарамт, шахалт үзүүлсэн зүйл байхгүй өдөр тутмын ажлаа хэвийн гүйцэтгэж байна. Нийслэлийн Мал аж ахуйн газрын ажлыг сайжруулах зорилгоор сэлгэж ажиллуулахаар ярилцаж байсан..." гэх тайлбарыг тус тус өгсөн байна.

Энэ талаар Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга "...мэргэжилтэн холбогдох асуудал 2020 оны 09 дүгээр сараас эхлэсэн бөгөөд ажлаас гарах өргөдлөө өг эсвэл өөр байгууллагад шилжүүлж ажиллуулна, ...мөн намайг бас дуудаж наад хүнээ явуул үгүй бол ажлаа өг гэж хэлсэн, ингэж сэтгэл зүйг нь тайван бус байлгаж өөрөөр нь ажлаас чөлөөлөгдөх

өргөдлийг нь өгүүлэх гэж байсан.

төрийн албан хаагч юм" гэсэн тайлбарыг өгсөн байна.

нь ажилдаа хариуцлагатай мэргэшсэн

Гомдолд хавсарган ирүүлсэн "Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийн газрын 2019 оны хагас жилийн ажлын гүйцэтгэлийн талаар хэлэлцсэн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хамт олны хурлын тэмдэглэлд "Төрийн албаны тухай хуулийн ахлах мэргэжилтний шаардлага хангасан нарыг албан тушаалын зэрэг ахиулахаар ... 100 хувийн саналаар тогтов" гэсэн байна. нь 2020 онд ажлын гүйцэтгэлийн үр дунгээр 96.5 хувь, 2021 оны жилийн эцэст 97.04 хувь буюу тус тус бүрэн хангалттай үнэлэгдсэн байна.

Дээрхээс үзэхэд ажил олгогч нь Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1-д "Хүн бүр хөдөлмөрлөх, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй", Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд "Энэхүү пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрнө" гэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад "энэ хуулийн 6.1-д заасан хориглосон үндэслэлээр ялгаварлан гадуурхах, бие махбод, сэтгэл зүйн дарамт, бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх замаар ажлын байрны тэвчишгүй орчныг үүсгэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд дээрх тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дараах Шаардлагыг хүргүүлж байна.

1. Тус яамны удирдах албан тушаалтнуудаас ажлын байрны дарамт үзүүлж байна гэх асуудлаар Комисст удаа дараа гомдол ирүүлж байгаад анхаарч, зөрчил гаргасан удирдах албан тушаалтанд хариуцлага тооцож, дахин зөрчил гаргахгүй байх;
2. Ажилтан, албан хаагч нар ажлын байрандаа ямар нэг дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх, удирдах албан тушаалтнуудыг хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;
3. Байгууллагын дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлэн боловсруулах;
4. Албан хаагч нь гомдол гаргах эрхийн хүрээнд дээд шатны албан тушаалтан, төрийн бусад байгууллагад өргөдөл, гомдол гаргаснаар аливаа ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байхад анхаарч ажиллах;

Шаардлагын мөрөөр холбогдох арга хэмжээг авч, биелэлтийг холбогдох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор бичгээр хариу ирүүлнэ үү.

Хувийг гомдол гаргагчид.

ГИШҮҮН



Х.МӨНХЗУЛ